



2019 ОНЫ
IV УЛИРЛЫН
ТАЙЛАН

“ЛэндМН ББСБ” ХК нь нийт харилцагчид болон хувьцаа эзэмшигчид та бүхэндээ 2019 оны 4-р улирлын санхүү болон үйл ажиллагааны тайлангаа танилцуулж байна.

Энэхүү тайландаа бид 2019 оны 4-р улирлын онцлох үйл явдлууд болон үндсэн тоон үзүүлэлтүүдийг танилцуулж байгаа бөгөөд 2019 оны нэгдсэн тайланг 2020 оны 2-р сарын 3-ны өдөр болох ТУЗ-ийн ээлжит хурлын дараа аудитлагдсан санхүүгийн тайлангийн хамтаар танилцуулах болно.

2019 оны 4-р улиралд “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьд өмнөх улирлуудын амжилтуудаа улам бататгаж, үйл ажиллагаагаа улам өргөжүүлсэн улирал болж өнгөрлөө. Үндсэн тоон үзүүлэлтүүд бүгд эерэг өсөлттэй байгаа бөгөөд бид энэ улиралд хэрэглэгчдийнхээ тоог нэмэхийн хажуугаар одоогийн зээлийн бүтээгдэхүүний нөхцөлөө сайжруулан, хугацаа хэтэрсэн зээлийг зохистой төвшнөөс илүү гаргахгүй байх тал дээр түлхүү анхаарч, бодлогын хэмжээнд шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ.

Ингэхдээ зээлийн бүтээгдэхүүнүүдийг нэгэнт хугацаа хэтэрсэн хойно арга хэмжээ авахаас илүүтэйгээр нарийвчилсан тоон шинжилгээнд үндэслэн хугацаа хэтрэх магадлалтай харилцагчийг эрт олж илрүүлэх, түүнчлэн анхнаасаа харилцагч тус бүрийн хэрэгцээнд тохирсон зээлийн бүтээгдэхүүн санал болгох системийг илүү нарийвчлан хөгжүүлэх тал дээр төвлөрч байгаа болно.

Мөн Монголбанкнаас “ЛэндМН ББСБ” ХК-ийг тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан гэх ташаа мэдээлэл гарсан тул холбогдох байгууллагууд руу албан тоот хүргүүлэн уг мэдээллийг залруулахыг хүссэн бөгөөд “ЛэндМН ББСБ” ХК нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос авсан тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа болно. Монголбанкны шаардаж буй энэхүү нэмэлт тусгай зөвшөөрлийг “ЛэндМН ББСБ” ХК-ийн доор охин компани байгуулан, уг компани дээр тусгай зөвшөөрлийг авахаар төлөвлөн ажиллаж байна.

2019 онд бидний нэвтрүүлсэн урт хугацааны зээл болон бэлтгэн нийлүүлэгчдэд зориулсан зээлийн бүтээгдэхүүнүүд маань амжилттай хэрэгжиж байгаа ба 2020 оны 1-р улиралд дараагийн шинэ зээлийн бүтээгдэхүүнийг олон нийтэд танилцуулахаар зорьж байна. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг 2019 оны жилийн эцсийн нэгдсэн тайлангаар харилцагч, хувьцаа эзэмшигч нартаа танилцуулах болно.

Хүндэтгэсэн
“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал
О.Болдбаатар

АГУУЛГА

- 1. ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- 2. НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ**
- 3. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- 4. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ**


1. ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“ЛэндМН ББСБ” ХК-ийн зээлийн гэрээ байгуулсан харилцагчийн тоо 2018 оны жилийн эцэст 94 мянга байсан бол 2019 оны жилийн эцэст 166 мянгад хүрч **75%-иар** нэмэгдлээ. 2019 онд нийт харилцагчдадаа **422 тэрбум** төгрөгийн **1.9 сая** удаагийн зээлийг **LendMN** апликашнээр дамжуулан олгосон байна. 2019 оны сүүлийн улиралд **575,000** удаагийн зээлийг олгож, олгосон зээлийн дүн **131.2 тэрбум** төгрөгт хүрсэн нь өнгөрсөн улирлын үзүүлэлттэй харьцуулахад зээлийн гэрээтэй харилцагчдын тоо **8%**, олгосон зээлийн тоо **12%**, олгосон зээлийн дүн **15%**, зээлийн багц **13%** тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2019 ОНЫ 4-Р УЛИРЛЫН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ӨМНӨХ ТАЙЛАНТ ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ


ГЭРЭЭТ ХАРИЛЦАГЧИД, ӨССӨН ДҮНГЭЭР

(Өссөн дүнгээр, мянган харилцагч)




ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ТОО

(Мянган зээл)




ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ДҮН

(Тэрбум төгрөг)



ЦЭВЭР ЗЭЭЛИЙН БАГЦ

(Тэрбум төгрөг)



2. НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ


EVENT SPACE

Бидний эргэн тойронд өдөр бүр болж байгаа сонирхолтой үзвэр үйлчилгээ, хурал зөвлөгөөн, арга хэмжээнүүдийн тасалбарыг бүгдийг нэг дороос худалдан авах болон худалдаалах боломжийг LendMN апликеийшн Event Space цэсээр дамжуулан олгож байна.

LendMN апликеийшны хэрэглэгчид өөрсдийн сонирхож байгаа арга хэмжээний тасалбарыг худалдаж авахаас гадна хувь хүн, албан байгууллагууд бидний энэхүү талбарт өөрсдийн зохион байгуулж байгаа бүхий л төрлийн арга хэмжээнүүдийг сурталчлан таниулах, тасалбараа худалдаалах боломж нээлттэй гэдгээрээ давуу талтай. Тасалбар борлуулалтын шинэ эрин цаасгүй тасалбар тэр дундаа апликеийшн суурьтай үйлчилгээ хэдийн орчин цагийн хэрэглээ болж байгаа ба үүнд яг тохирох үйлчилгээг бид санал болгож байна.



Event Space



ПРАКТИКАЛ ДААТГАЛ

Өнөөгийн нөхцөлд эрсдэлийг удирдах хамгийн сонгодог арга нь даатгал юм. Монгол улсын хэмжээнд даатгалын бүтээгдэхүүний нэр төрөл жилээс жилд өсөн нэмэгдэж олон улсын стандартад нийцсэн төрөл бүрийн даатгалын бүтээгдэхүүн зах зээлд нэвтэрсээр байна. Энэхүү салбарын өсөлтийг дагаад хэрэглэгчид даатгалын үйлчилгээг сонгохдоо нөхөн төлбөрийн хэмжээ, шуурхай үйлчилгээ болон хамгийн хялбар байдлаар үйлчилгээ авахыг чухалчилдаг болсон билээ.

LendMN аппликашнд үндэсний тэргүүлэгч даатгалын компани Практикал даатгал нэгдсэнээр бидэнтэй хамтран даатгалын үйлчилгээ үзүүлэгч З дахь байгууллага болж байна. LendMN аппликашны хэрэглэгч бүрт томоохон даатгалын компаниуд болох Номин даатгал, Хаан даатгал, Практикал даатгал компаниудын үйлчилгээг нэгтгэн, болзошгүй бүхий л төрлийн эрсдэлээс таныг хамгаалах үйлчилгээг хамгийн хялбараар хүргэж байгаадаа баяртай байна.



FLOWER FAIRY


Улаанбаатар хотын завгүй амьдралын хэв маягт хайртай дотнын хүмүүсийнхээ нандин мөчүүдийг хуваалцах боломж илүү ойртлоо. Хүргэлтийн үйлчилгээний давуу талыг ашиглан, гоёмсог амьд цэцгийн цоморлогийг хамгийн эрхэм нэгэндээ захиалан хүргүүлэх үйлчилгээ орсноор LendMN аппликашны аз жаргалыг түгээх цэс дахин нэгээр нэмэгдлээ.

Цэцгийн баглаа нь өөрөө орчин цагийн онцлогийг тусгасан зохиомж болон цэцгийн өвөрмөц сортоороо ялгарч байдаг бөгөөд энэхүү соёлыг хэрэглэгчдэд шинэлэг байдлаар түгээж буй Flower Fairy цэцгийн дэлгүүр бидэнтэй нэгдсэнийг дуулгахад таатай байна.



Flower Fairy

**Flower Fairy онцгой
цэцгүүдийг LendMN-р
захиалдаг боллоо.**



“BLACK MONTH” - 2019 ОНЫ 11 САР

Дэлхийн өнцөг булан бүрт хүн бүрийн хүлээдэг томоохон худалдааны тэсрэлт бол яхын аргагүй **Black Friday** буюу Хар баасан гаригийн хямдрал билээ. Жилээс жилд Хар баасан гаригт зориулсан худалдаа үйлчилгээ, хямдрал урамшуулал илүү онлайн дэлгүүр, цахим сувгуудруу чиглэж байгаа бөгөөд **LendMN апликашн** энэхүү худалдааны трэндтэй хөл нийлүүлэн 2019 оны 11-р сард харилцагч байгууллагуудтайгаа хамтран **30-80%** хямдрал эдлэх боломжтой томоохон онлайн хямдралыг зарласан нь олон хэрэглэгчдийн талархлыг хүлээсэн онцолхуйц үйл явдал боллоо.



30%
20%
50%
60%
70%
80%



“КУПОН БЭЛЭГЛЭЕ” - 2019 ОНЫ 12 САР

“ЛэндМН ББСБ” ХК-с шинэ жилийн баярыг тохиолдуулан өдөр тутмын өөрт хэрэгтэй бүх үйлчилгээгээ LendMN аппликеийшнээс авдаг эрхэм хэрэглэгчдээ урамшуулах зорилгоор 2019 оны 12-р сарыг **“Купон бэлэглэх”** сар болгон зарлалаа. Энэхүү урамшууллын хүрээнд LendMN аппликеийшны 26 төрлийн нэмэлт үйлчилгээнээс өөрийн амьдралын хэв маягт тохирсон үйлчилгээг сонгон ашигласан, хамтран ажиллагч 200 гаруй байгууллагуудын баярын өдрүүдэд зориулсан хамгийн эрэлттэй бүтээгдэхүүн үйлчилгээг хямдралтай үнээр худалдан авсан, шинэ жилийн баяраар хайртай дотнын хүмүүсээ баярлуулах бэлгийн сонголтоо Лэндийн онлайн дэлгүүр болох Banana Mall-с хийсэн бүх хэрэглэгчдээдээ купон илгээж бэлэг барилаа.



- Gegenanten**: VIP танхим /хос тасалбар/ - 50% сэргээс 30'000₮
- JET Teeris**: ТУРГЭВЧИЛСЭН ВАКУМЖУУЛСАН СУРГАЛТ - 70% сэргээс 55'000₮
- Pizza Hut**: ПИЦЦАНЫ COUPON БЭЛЭГЛЭЕ! - 15% сэргээс 58'650₮
- LUSTRE**: Lustre Brand: Онлайн куртка - Хэмжээ 5, M, L - 30% сэргээс 118'300₮
- Panda Bubble Tea**: Panda Bubble Tea: Бүт төрлийн BOBA - 70% сэргээс 2370₮
- Мабы**: Мабы Арап: Тэрбумтан - Халгат тоглоом - 30% сэргээс 62'300₮
- Эрбумтган**: Эрбумтган - 100% сэргээс 62'300₮

3. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“ЛэндМН ББСБ” ХК-ийн санхүүгийн тайландаа Эрнст Энд Янг Монголиа Аудит хөндлөнгийн аудит хийж байгаа ба 2019 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайланг 2019 оны 2-р сарын 3-ны өдөр Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хуралд танилцуулан батлуулсны үндсэн дээр олон нийтэд танилцуулах бөгөөд мөн хурлаар Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын тов болон 2020 онд хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээг батлах юм. Хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид та бүхэнд компанийн 2019 оны 4 дүгээр улирлын байдлаарх санхүүгийн урьдчилсан үр дүнг танилцуулж байна.

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН /Аудитлагдаагүй/

Компанийн нийт хөрөнгийн хэмжээ 2019 оны 4-р улиралд **58.1 тэрбум** төгрөгт хүрч өмнөх улирлаас **7.3 тэрбум** төгрөгөөр буюу **14.3%-иар**, өмнөх оны мөн үеэс **33.8 тэрбум** төгрөгөөр буюу **139%-иар** тус тус өссөн байна.

Хөрөнгө /Тэрбум төгрөг/	2019 1-р улирал	2019 2-р улирал	2019 3-р улирал	2019 4-р улирал
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1.8	9.7	6.2	6.8
Зээлийн багц (цэврээр)	29.9	35.8	42.7	48.5
Авлага	1.0	1.7	1.1	1.4
Үндсэн хөрөнгө	0.3	0.4	0.4	1.2
Биет бус хөрөнгө	0.4	0.4	0.4	0.3
Нийт хөрөнгө	33.4	48.0	50.8	58.1

Өр төлбөр /Тэрбум төгрөг/	2019 1-р улирал	2019 2-р улирал	2019 3-р улирал	2019 4-р улирал
Эх үүсвэр	17.7	31.3	32.8	38.0
Хуримтлагдсан хүүгийн өглөг	0.4	0.6	0.6	0.6
Хэтэвчийн үлдэгдэл	0.6	0.6	0.9	1.0
Бусад өглөг	0.9	0.9	0.5	1.4
Нийт өр төлбөр	19.6	33.4	34.9	40.9

Эздийн өмч /Тэрбум төгрөг/	2019 1-р улирал	2019 2-р улирал	2019 3-р улирал	2019 4-р улирал
Хувьцаат капитал	10.8	10.5	10.5	10.5
Тухайн жилийн ашиг	1.2	2.6	3.7	4.9
Хуримтлагдсан ашиг	1.7	1.7	1.7	1.7
Эздийн өмчийн дүн	13.8	14.8	16.0	17.2
Нийт өр төлбөр болон эздийн өмч	33.4	48.2	50.8	58.1

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ /Сая төгрөг/

	2019 1-р улирал	2019 2-р улирал	2019 3-р улирал	2019 4-р улирал
Нийт зээлийн багц	30,652	36,850	44,100	50,007
Хэвийн зээл	29,293	34,817	41,364	47,055
Багцад эзлэх хувь	95.6%	94.5%	93.8%	94.1%
Хугацаа хэтэрсэн зээл	791	1,032	1,347	1,218
Багцад эзлэх хувь	2.6%	2.8%	3.1%	2.4%
Чанаргүй зээл	568	1,001	1,390	1,735
Багцад эзлэх хувь	1.9%	2.7%	3.2%	3.5%
Эрсдэлийн сан	710	1,058	1,373	1,597
Эрсдэлийн сангийн хүрэлцээ	125%	106%	99%	92%

2019 оны 3-р улирлын байдлаар Банк Бус Санхүүгийн салбарын нийт зээл 1,169 тэрбум төгрөг байснаас Хэвийн зээл 1,016 тэрбум төгрөг (86.9%), Хугацаа хэтэрсэн зээл 49 тэрбум төгрөг (4.2%), Чанаргүй зээл 105 тэрбум төгрөг (9.0%) байсан үзүүлэлттэй байна. Мөн хугацаанд салбарын хэмжээнд зээлийн эрсдэлийн сан 78.3 тэрбум төгрөг буюу эрсдэлийн сангийн хүрэлцээ 74.6%-тай байна.

Дээрхтэй харьцуулахад 2019 оны 4-р улирлын байдлаар "ЛэндМН ББСБ" ХК-ийн Нийт зээлийн багц 50 тэрбум байгаагаас Хэвийн зээлийн багц 47.1 тэрбум (94.1%), Хугацаа хэтэрсэн зээлийн багц 1.2 тэрбум төгрөг (2.4%), Чанаргүй зээлийн багц 1.7 тэрбум төгрөг (3.5%) байна. Тус хугацаанд зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 1.6 тэрбум төгрөг байгаа нь эрсдэлийн сангийн хүрэлцээ 92% байгааг харуулж байна.


ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН /Аудитлагдаагүй/

2019 оны 4-р улирлын орлогын хэмжээ **5.8 тэрбум** төгрөгт хүрч, **1.2 тэрбум** төгрөгийн цэвэр ашигтай ажилласнаар компанийн 2019 оны нийт цэвэр ашиг **4.9 тэрбум** төгрөг болж өмнөх онтой харьцуулахад **92%-иар** өссөн үзүүлэлттэй байна.

Хөрөнгө /Тэрбум төгрөг/	2019 1-р улирал	2019 2-р улирал	2019 3-р улирал	2019 4-р улирал	2019 Жилийн эцэс
Нийт орлого	3.5	4.3	4.9	5.8	18.5
Хүүгийн зардал	(0.6)	(1.1)	(1.3)	(1.5)	(4.5)
Санхүүгийн цэвэр орлого	2.9	3.2	3.6	4.4	14.0
Банкны болон бусад шимтгэл	(0.4)	(0.5)	(0.5)	(0.5)	(1.9)
Шимтгэлийн дараах орлого	2.5	2.7	3.1	3.8	12.1
Эрсдэлийн сангийн зардал	(0.3)	(0.4)	(0.5)	(0.5)	(1.6)
Эрсдэлийн сангийн дараах орлого	2.2	2.4	2.5	3.4	10.5
Боловсон хүчний зардал	(0.4)	(0.4)	(0.6)	(0.6)	(2.0)
Үйл ажиллагааны бусад зардал	(0.5)	(0.5)	(0.5)	(1.0)	(2.5)
Татварын өмнөх ашиг	1.4	1.5	1.5	1.7	6.0
Татварын зардал	(0.1)	(0.2)	(0.4)	(0.5)	(1.1)
Цэвэр ашиг	1.2	1.3	1.1	1.2	4.9


ОРЛОГО, ӨССӨН ДҮНГЭЭР

(Тэрбум төгрөг)



ЦЭВЭР АШИГ, ӨССӨН ДҮНГЭЭР

(Тэрбум төгрөг)



4. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2019 оны 4 дүгээр улиралд ээлжит 2, ээлжит бус, эчнээ 2 удаагийн хурлаар хэд хэдэн чухал шийдвэрүүдийг гаргалаа.

ТУЗ-ийн хурлаас гарсан онцлох шийдвэрүүдийг дурьдавал:

- ✓ Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс “ЛэндМН ББСБ” ХК-ийн “Эрсдэлийн удирдлагын бодлого”, “Зээл, түүнтэй адилтгах активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлого”, “ЛэндМН ББСБ ХК-ийн ёс зүйн дүрэм”-ийг баталлаа.
- ✓ Эрсдэлийн бодлогын хүрээнд 2017 оноос хуримтлагдсан 266.4 сая төгрөгийн зээл, түүнд тооцсон 15.6 сая төгрөгийн шимтгэлийн авлагыг Зээлийн эрсдэлийн сангаас хаах шийдвэр гаргав.
- ✓ “ЛэндМН ББСБ” ХК-ийн “Санхүүгийн эрсдэлийн бодлого”, “Эх үүсвэрийн 2019 оны төлөвлөгөө”-ний хүрээнд зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор зарим банкнаас зээл авах, гадаад валютын эх үүсвэрийн ханшийн эрсдэлийг удирдах зорилгоор зарим банктай хэлцэл хийх эрхийг Гүйцэтгэх захиралд олголоо. Мөн “Анд Системс” ХХК, “Анд Системс Tex” ХХК-аас зээлийн үйл ажиллагаанд зориулан санхүүжилт татах сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрлийг олголоо.
- ✓ Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс 2019 оны санхүүгийн тайланд аудит хийх байгууллагаар “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийг сонгох шийдвэр гаргасны дагуу 2019 оны 11 дүгээр сараас хөндлөнгийн аудитын ажил хийгдэж байна.
- ✓ Мөн Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасан үйл ажиллагааг Монголбанкнаас олгосон зөвшөөрлийн дагуу эрхлэх, түүнтэй холбоотой “ЛэндМН ББСБ” ХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани байгуулах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 2.5 тэрбум төгрөгөөр тогтоох шийдвэрийг гаргалаа.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрүүдтэй Монголын Хөрөнгийн Биржийн (<http://mse.mn/mn>) цахим хуудаснаас танилцах боломжтой.

Холбоо барих:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ж.Мөнхцэцэг

Утас: 9901-8886

Имэйл: board@lend.mn



БАЯРЛААА